

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванзагал сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/013/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4204, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [narmandakh@audit.gov.mn](mailto:narmandakh@audit.gov.mn)  
Аудитор: Б.Одхүү  
Утас: 7058-4207, Цахим хаяг: [odkuu@audit.gov.mn](mailto:odkuu@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
5.1 Албан шаардлага .....	
5.2 Зөвлөмж .....	17
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	10

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025-03-24 № 46

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Гурванзагал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванзагал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Гурванзагал сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 03/10 дугаар тогтоолоор "эрчимжүүлэх шаардлагатай" гэж дүгнэсэн байна.

011022207

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>561,504.4</b>	<b>580,063.3</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	246,223.7	265,352.8
33	<b>АВЛАГА</b>	192,995.6	150,710.4
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	122,285.1	122,640.1
	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>		41,360.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,134,997.1</b>	<b>2,172,915.9</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,134,997.1	2,172,915.9
39200	<b>Биет хөрөнгө</b>	2,116,809.4	2,152,465.9
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	18,187.7	20,450.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,696,501.5</b>	<b>2,752,979.2</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>32.4</b>	<b>50,909.9</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	32.4	50,909.9
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,696,469.1</b>	<b>2,702,069.3</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,696,469.1</b>	<b>2,702,069.3</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	358,325.5	358,325.5
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,092,515.2	2,098,115.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	245,628.4	245,628.4
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,696,501.5</b>	<b>2,752,979.2</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,950,323.6</b>	<b>2,212,444.5</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>326,478.0</b>	<b>470,618.5</b>
110	Орлогын албан татвар	136,275.7	338,943.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	141,168.3	357,721.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(4,892.6)	(18,777.6)
113	Хөрөнгийн албан татвар	115,999.6	126,482.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	74,202.7	5,192.8
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>840,137.7</b>	<b>317,843.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого	840,137.7	317,843.4
121	Хөрөнгийн орлого		
122	Тусламжийн орлого		
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,783,707.9</b>	<b>1,423,982.6</b>
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,833,480.7</b>	<b>1,571,793.2</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>958,045.5</b>	<b>1,467,264.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>958,045.5</b>	<b>1,467,264.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	432,618.1	700,100.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,372.3	91,898.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,104.5	34,605.3
2104	Хангамж, бараа материалын зардал	57,892.5	59,488.6
2105	Нормативт зардал	3,133.9	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,997.4	7,395.0
2107	Томилолт, зочны зардал	8,484.0	11,460.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,945.4	163,982.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	251,497.4	398,333.9
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>875,435.2</b>	<b>104,529.2</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>-</b>

Гурванзагал сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,116,842.9	640,651.3
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	386,582.1	635,051.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	730,260.8	5,600.2

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,966,208.4		1,966,208.4
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,966,208.4		1,966,208.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
7	Өмчид гарсан өөрчилөлт			
8	Зарласан ногдол ашиг			
9	Тайлант үеийн үр дүн	730,260.8		730,260.8
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,696,469.1		2,696,469.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,696,469.1		2,696,469.1
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,696,469.1		2,696,469.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт			
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			
17	Өмчид гарсан өөрчилөлт			
18	Зарласан ногдол ашиг			
19	Тайлант үеийн үр дүн	5,600.2		5,600.2
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,702,069.3		2,702,069.3

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,163,863.4	1,986,901.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	326,478.0	470,618.5
110	Орлогын албан татвар	136,275.7	338,943.6
1100	Хувь хүний орлогын албан татвар	141,168.3	357,721.2
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(4,892.6)	(18,777.6)
113	Хөрөнгийн албан татвар	115,999.6	126,482.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	74,202.7	5,192.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,455.1	1,700.7
1181	Газрын төлбөр	72,747.5	3,492.2
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	53,677.5	92,300.5
120	Нийтлэг татварын бус орлого	53,677.5	92,300.5
122	Тусламжийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,783,707.9	1,423,982.6

Гурванзагал сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,641,529.4</b>	<b>1,361,162.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,641,529.4</b>	<b>1,361,162.3</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>766,094.2</b>	<b>1,256,633.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	442,618.1	705,100.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,372.3	92,979.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,080.5	44,779.6
2104	Хангамж, бараа материалын зардал	44,794.6	51,285.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,886.2	7,735.0
2107	Томилолт, зочны зардал	8,484.0	11,460.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,695.4	163,982.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,163.1	179,311.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	875,435.2	104,529.2
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>522,334.0</b>	<b>625,739.3</b>
IV	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	-	-
V	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>413,369.1</b>	<b>606,610.2</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>413,369.1</b>	<b>606,610.2</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	413,369.1	606,610.2
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(413,369.1)</b>	<b>(606,610.2)</b>
VII	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(70,000.0)</b>	-
14	Бусад эх үүсвэр	-	-
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>70,000.0</b>	-
25	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>70,000.0</b>	-
VIII	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>38,964.9</b>	<b>19,129.1</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	207,258.8	246,223.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	246,223.7	265,352.8

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

			/мянган төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,030,097.5</b>	<b>1,768,718.3</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,220,144.1</b>	<b>1,172,448.1</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,145,614.6</b>	<b>1,097,918.9</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,464.9	700,100.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,109.3	92,979.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,625.3	187,668.9
2104	Хангамж, бараа материалын зардал	37,577.2	36,735.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,750.2	21,725.5
2107	Томилолт, зочны зардал	8,850.0	8,850.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,575.1	6,502.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,662.6	43,357.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>74,529.5</b>	<b>74,529.2</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,529.5	74,529.2

Гурванзагал сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	709,953.4	596,270.2
23	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	100,000.0	-
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,030,097.5</b>	<b>1,726,956.1</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
32	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,728,729.2	1,677,911.4
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	301,368.3	49,044.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	-	221,247.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	-	175,871.2
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3</b>	<b>3</b>
610001	Төсвийн байгууллага	3	3
610002	Төсвөөс гадуур байгууллага	0	0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>27</b>	<b>22</b>
620001	Удирдах ажилтан	8	7
620002	Гүйцэтгэх ажилтан	12	9
620003	Үйлчлэх ажилтан	7	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>141,190.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>141,190.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>141,190.4</b>
2104	Хангамж, бараа материалын зардал	806.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000.0
2107	Томилолт, зочны зардал	2,610.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,773.7
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>141,190.4</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	141,190.4

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 30.2 сая төгрөгийн 6 зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 30.2 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

1. ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогчоор хамаарал бүхий албан хаагчийг томилуулан ажиллуулсан байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **3.2 Зөвлөмж**

#### **1. Илрүүлэлт**

Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг 2 бодлого, 16 зорилт, 170 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, биелэлтийг 80.0 хувиар тайлагнасан байна. Гурванзагал сумын ИТХ нь 2024 хөгжлийн төлөвлөгөөг 70 хувиар буюу "эрчимжүүлэх шаардлагатай" гэж дүгнэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

#### **Өгсөн зөвлөмж**

Сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах.

#### **2. Илрүүлэлт**

Сумын ТТЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл, арга хэмжээний нийт хэрэгжилт 84.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

*Орон нутгийн хөрөнгө оруулалт:* Тайлант онд 28.0 сая төгрөгийн 7 ажил хийхээр төлөвлөгөө батлагдсан байна. Гүйцэтгэлээр 28.0 сая төгрөгөөр 7 ажил хийгдсэн байна. Хэрэгжилт 100.0 хувь байна.

*Байгаль хамгаалах сан:* Тайлант онд 10.3 сая төгрөгийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулсан байна. Гүйцэтгэлээр 6.3 сая төгрөгөөр 2 ажил хийгдэж, төлөвлөсөн арга хэмжээнүүд 61.1 хувь хэрэгжсэн байна.

*ОНХС:* ОНХС-ийн хөрөнгөөр 706.9 сая төгрөгийн 20 ажлыг хийхээр төлөвлөж 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж**

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

#### **3. Илрүүлэлт**

Сумын татварын орлого нийт дүнгээрээ 112.8 хувиар биелсэн ч бууны албан татвар 95.0 хувь, малд ногдуулах албан татвар 85.2 хувьтай биелсэн байна. Татварын бус орлого 209.6 хувиар биелсэн байна.

Малын хөлийн татвар жилийн эцсийн байдлаар 20.6 сая төгрөгийн дутуу биелэлттэй байсан бол 2025 оны 1-3 сард 16.5 сая төгрөгийн орлогыг нөхөн төвлөрүүлсэн байна.

#### **зөвлөмж**

Татварын орлогыг нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх.

#### **4. Илрүүлэлт**

Хоршоо хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулж зээл олгох эх үүсвэр бүрдсэн ч 2024 онд ХХС-ийн журмын дагуу төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, зээл олгоогүй байна. Энэ нь "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 2.10 дахь "Төсөл сонгон шалгаруулах товыг зээлийн эргэн төлөлт, санхүүжилтийг харгалзан сангийн эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**зөвлөмж**

ХХС-ийн журмын дагуу төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж, зээл олгох.

**5. Илрүүлэлт**

ОНХС-ийн хөрөнгөөр 706.9 сая төгрөгийн 20 ажлыг хийхээр төлөвлөж 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: 26.3 сая төгрөгийн 2 ажил 50-60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**зөвлөмж**

ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогчоор хамаарал бүхий албан хаагчийг томилуулан ажиллуулсан байна	1	0			1	0							
Сумын хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг	1	0					1	0					

**Гурванзагал сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

хангаж ажиллаагүй												
Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллаагүй	1	0					1	0				
Татварын орлогыг нэр төрлөөр нь биелүүлж ажиллаагүй	1	4.1					1	4.1				
Хоршоо хөгжүүлэх сангаас төсөл сонгон шалгаруулж зээл олгох эх үүсвэр бүрдсэн ч 2024 онд ХХС-ийн журмын дагуу төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулаагүй, зээл олгоогүй байна.	1	0					1	0				
ОНХС-ийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллаагүй	1	26.2					1	26.2				
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>30.2</b>			<b>1</b>	<b>0</b>	<b>5</b>	<b>30.2</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТТЗ	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>					<b>1</b>	<b>-</b>



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 198 А/170308

Чойбалсан хот

SOA-2025/013/НА-СТА-ТТЗ

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Гурванзагал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Гурванзагал хөгжил” ОНӨААТҮГ-ын даргын хамаарал бүхий этгээд нь тус байгууллагын нягтлан бодогчоор ажиллаж байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11 дэх “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 05-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Гурванзагал сумын Засаг дарга Д.Доржбаатар, санхүүгийн албаны дарга С.Билэгсайхан нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



И.СЭМЖИДМАА  
Б.ОДХҮҮ

2125040585